



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 5/88

Чингис хот

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.7 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/”-ын 136.4.2-ын “б” заалт, 136.5.2-ын “г” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Сахилгын шийтгэл оногдуулах журам /код-914/”-ын 914.3.1 дэх заалт, Цагдаагийн газрын даргын 2017 оны 08 дүгээр сарын 07-ний өдрийн ээлжит 14 дүгээр зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Нэргүй нь гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг удаа дараа дарагдуулсан, ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн ажлаа хангалтгүй хэрэгжүүлж, гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг заавал хүлээж авах ЭБШХ-ийн 170 дугаар зүйл, гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гаргах шийдвэр ЭБШХ-ийн 172 дугаар зүйл, ЭБШХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1, 16 дугаар зүйлийн 16.1, 28 дугаар зүйлийн 28.2.12-д заалт, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.5 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байх тул цагдаагийн дэслэгч Б.Нэргүйгийн албан тушаалын үндсэн цалингийн 3 сар хүртэл хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Сахилгын зөрчил дутагдал гаргасан цагдаагийн дэслэгч Б.Нэргүйд дахин зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр баталгаа авч, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7 дахь заалтыг үндэслэн төлбөртэй сургалтанд хамруулж, холбогдох хууль, дүрэм, журмуудыг өөрсдөөр нь судлуулах, үр дүнг тооцох, хариуцсан алба хаагч нартаа бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Баярсайханд үүрэг болгосугай.

3.Сахилгын арга хэмжээ авагдсан цагдаагийн дэслэгч И.Сүхбатын албан тушаалын үндсэн цалинг заасан хувиар хасаж олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

5.Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Ж.БОЛД

